



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2016 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

1. Засгийн газрын 2016 оны 174 дүгээр тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, боловсронгуй болгох талаар санал боловсруулах, төлөвлөгөө хэрэгжүүлэхтэй холбогдуулан салбар хоорондын уялдааг хангуулах, зохицуулалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:


- Дарга: -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
- Дэд дарга: -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
- Гишүүд:
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын орон нутгийн асуудал хариуцсан дэд дарга;
 - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга;
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын дарга;
- Барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан Засгийн газрын референт.

Нарийн бичгийн дарга:

- Нийслэлийн Засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Ажлын хэсэг байгуулах тухай” Ерөнхий сайдын 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 69 дүгээр захирамжийн 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ